

**СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ТӨРИЙН ӨМЧИТ ЦЭЦЭРЛЭГ
БОЛОН СУРГУУЛИУДААС АВСАН СЭТГЭЛ
ХАНАМЖИЙН СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

2022 он

2022 оны IV улиралд Сонгинохайрхан дүүргийн төрийн өмчит цэцэрлэг болон сургуулиудаас түгээгдэж буй бараа бүтээгдэхүүний чанар, үйлчилгээний хүртээмж, түгээлтийн ажилчдын зан харьцаа ёс зүйн талаар 5 асуулга бүхий сэтгэл ханамжийн судалгааг авч ажиллалаа. Тус судалгаанд нийт 64 цэцэрлэг, 7 сургууль, 1 эмнэлэг хамрагдахаас 37 цэцэрлэг, 5 сургууль, 1 эмнэлэг буюу 59,7% нь хамрагдаж, өөрсдийн бодол, санал хүсэлтээ солилцож, үнэлэлт дүгнэлт өгч ажиллалаа.

Тус асуулгад хамрагдсан цэцэрлэгүүдээс нийт 32 санал ирүүлсэн байна.

Үүнд:


1. Өвлийн улиралд хүнсний зарим ногоо хайрагдаж ирэх, хаягдал их гарах
2. Үхрийн мах зарим тохиолдолд туранхай ирэх, махыг ууттай болгох
3. Махны үнэ өндөр
4. Жигнэмгийн нэр төрлийг нэмэгдүүлэх
5. Хуурай сүү, хуурай өндөг, улаан давс, чангаанз, орос жигнэмэг, тахианы мах, нэрсний шүүс зэрэг бүтээгдэхүүнийг авах хүсэлтэй зэрэг саналуудыг ирүүлсэн бөгөөд хамтран ажиллахад таатай, ажлын амжилт хүссэн байна.

Асуулгад:

1. Түгээгдэж буй бараа бүтээгдэхүүний нэр төрөлд үнэлгээ өгнө үү? гэсэн асуулгад 93% нь хангалттай, 7% нь хангалтгүй гэсэн үнэлгээ өгсөн байна.

а. Хангалттай - 40

б. Хангалтгүй – 3




2. Түгээгдэж буй бүтээгдэхүүний чанарт үнэлгээ өгнө үү? гэсэн асуулгад 72% нь сайн, 28% нь дунд гэсэн үнэлгээ өгсөн байна.

а. Сайн - 31

б. Дунд -12

в. Муу -0




3. Манай байгууллагаас үзүүлж буй үйлчилгээний хүртээмжийг хэрхэн үнэлэх вэ? гэсэн асуулгад 28% нь маш сайн, 67% нь сайн, 5% нь дунд гэсэн үнэлгээ өгсөн байна.

а. Маш сайн - 12

б. Сайн -29

в. Дунд - 2

г. Муу -0




4. Манай байгууллагын түгээлтийн ажилчдын зар харьцааг та хэрхэн үнэлж байна вэ? гэсэн асуулгад 44% нь маш сайн, 54% нь сайн, 2% нь муу үнэлгээ өгсөн байна

а. Маш сайн -19

б. Сайн - 23

в. Дунд -0

г. Муу - 1



САНАЛ ГОМДЛЫН МӨРӨӨР АВСАН АРГА ХЭМЖЭЭ:

Дээрх судалгаагаар ирсэн санал гомдлын дагуу цэцэрлэгүүдтэй холбогдон цаг тухай бүрд нь чанарын шаардлага хангаагүй бүтээгдэхүүнийг буцаан авч, чанарын шаардлага хангасан бүтээгдэхүүнээр сольж өгч, бэлтгэн нийлүүлэгч гэрээт байгууллагуудтай холбогдон хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангасан бүтээгдэхүүнийг нийлүүлэх талаар санал хүргүүлж гомдлыг барагдууллаа. Мах, махан бүтээгдэхүүн нийлүүлэгч “Хулагу холдинг” ХХК-тай холбогдон махыг ууттай болгох, хүнсний ногоо бэлтгэн нийлүүлэгч “Эрдэнэ-Энх трейд” ХХК-тай холбогдон хүнсний ногоог дахин ангилж, соортлуулан хаягдалгүй болгох талаар анхааруулав. 2022 оны 12 дугаар сараас эхлэн чангаанз, нэрсний варень /600гр/, бүхэл үрийн жигнэмэг /4*200гр/, хоох жигнэмгийг шинээр захиалгад оруулан түгээн ажиллаж байна.

ДҮГНЭЛТ

Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаанд хамрагдсан нийт 43 байгууллагаас хүнсний бүтээгдэхүүний чанар, үзүүлж буй үйлчилгээний хүртээмж, бүтээгдэхүүний нэр төрөл, түгээлтийн ажилчдын зан харьцааны талаар “Хангалттай” үнэлгээ авч ажиллалаа. Дэлхий нийтээр Ковид-19 цар тахал болон ОХУ-д үүсэн асуудалтай холбогдуулан зарим бараа бүтээгдэхүүний хомсдол үүсэж, үнэ өсөж байгаа боловч хүнсний бүтээгдэхүүний нэр төрлийг хүүхдийн хоолны стандарт шаардлага хангасан бүтээгдэхүүнээр төрөлжүүлэн, нэмэгдүүлж, бараа бүтээгдэхүүний үнийг тогтмолжуулах талаар судалгаа хийж байна. Цэцэрлэгүүдээс ирүүлсэн санал хүсэлт, гомдлыг цаашдын үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлэхээр ажиллаж байна.